## “БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ
## 2021 ОНЫ 10 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2021 оны 10 дугаар сарын 29

Багануур дүүрэг

| № | ҮНДЭСЛЭЛ | ХИЙСЭН АЖЛЫН БИЕЛЭЛТ | ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУВЬ |
|---|---|---|---|
| 1. | БҮТП-ийн Ерөнхий төлөвлөгөө, инженерийн шугам сүлжээний зураг төсөл | - Байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүрэг, МУЗГ-ын 2020 оны 203 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 6.1.11.3, НЗД-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.2.2.2 дахь заалтын хүрээнд Мон-Энержи Консалт ХХК-ийн гүйцэтгэж байгаа паркийн гадна инженерийн шугам сүлжээний зураг төслийн цахилгааны хэсгийн ажлын зураг боловсруулах явцад зургийн даалгаврын дагуу хяналт тавьж ажиллаж байна.<br>- Паркийн цахилгаан хангамжийн зураг төсөл ЭХЯ-ны эрчим хүчний хөгжлийн төвийн магадлалаар хянагдаж бүрэн дууссан.<br>- БҮТП-ийн Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөлт, гадна инженерийн шугам сүлжээний зураг төсөл боловсруулах 2018/10 тоот гэрээт ажлыг хүлээлцэх ажиллагааг 10 дугаар сарын 21, 26-нд тус тус зохион байгуулж ажилласан.<br>- Паркийн зүгээс эрчим хүчний зураг төслийн гүйцэтгэл дээр зарим ажлуудыг нэмж гүйцэтгэх зөвлөмж өгч ажилласан. Уг зөвлөмжийн хүрээнд нэмж гүйцэтгүүлэх ажлыг эрчимжүүлж ажиллахаар зорьж байна. | 100% |
| 2. | | Паркийн хүнд үйлдвэрийн бүсийн цахилгаан хангамжийн 35кВ-ын өндөр хүчдэлийн агаарын шугамыг 35/10 кВ-ын дэд станцын хамт барих хөрөнгө оруулалтыг дэмжин хамтран ажиллах боломжтой гадаад, дотоодын байгууллагуудын судалгаа гаргасан. | 100% |
| 3. | | - Нийслэлийн 2022 оны төсвийн төсөл хэлэлцэхтэй холбогдуулан 2022 онд нэн шаардлагатай төсөв, хөрөнгө оруулалтын саналыг улс, нийслэлийн төсөвт тусгуулах тухай 142, 146,147 дугаартай албан бичгийг НЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга, Багануур дүүргийн Засаг дарга, Багануур дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга нарт тус тус хүргүүлсэн.<br>- Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн цахилгаан хангамжийн зураг төсөл дуусч, парк байгуулах бэлтгэл ажил бүрэн хангагдаж, 2022 онд паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажил эхлэх гэж байгаатай холбогдуулан нэн шаардлагатай ерөнхий цахилгаан хангамжийн 110/35/10 кВ-ын үндсэн дэд станцыг барих санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлэхээр саналыг Багануур дүүргээс сонгогдсон Улсын их хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Улсын их хурлын гишүүн, шадар сайд С.Амарсайхан, Эрчим хүчний сайд | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | Н.Тавинбэх нарт 2021 оны 10 дугаар 08-ны өдрийн 143;144,145 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. | |
| 4. | Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.1.2 | Нийслэлийн 2022 оны төсөвт оруулах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсвийг бэлтгэн, байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрөл, газрын гэрчилгээ, батлагдсан зураг төсөв, техникийн нөхцөлийн баримт бичгийг хавсарган 2021 оны 10 дугаар сарын 22-ны өдөр НШУҮИГ-ын Хөнгөн үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтний цахим хаягаар хүргүүлсэн. | 100% |
| 5. | Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.4.3 | Паркаас боловсруулсан ахуйн болон үйлдвэрлэлийн хог, хаягдлын менежментийн дагуу компост бордоо хийх технологийн сургалтыг товч байдлаар бэлтгэн байгууллагын цахим хуудсаар дамжуулан иргэдэд хүргэж байна. | 100% |
| 6. | Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.2.4 | - ЗГ-ын 2021 оны 96 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах үүднээс албан хаагчдад монгол бичгийн мэдлэг олгох дунд шатны 8 цагийн сургалтыг Албан бус-насан туршийн боловсролын төвөөс авсан. Албан хаагчид монгол бичгийн анхан шатны мэдлэгээ сэргээж, дунд шатны түвшинг эзэмшсэн маш үр дүнтэй сургалт болсон.<br>- Багануур дүүргийн Газар зохион байгуулалтын албанаас зохион байгуулж байгаа “Цахим шилжилт хамтын шийдэл” сургалтыг 10 дугаар сарын 12-ны өдөр байгууллага дээр авсан.<br>- Гал түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулж буй “Алдвал галдана” сарын аяны хүрээнд албан хаагчдыг түүнтэй тэмцэх арга барилд сургах үүднээс дүүргийн Онцгой байдлын хэлтэсээс гал түймрээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх чиглэлийн сургалтыг 10 дугаар сарын 13-ны өдөр авсан. | 100% |
| 7. | Нийслэлийн Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А/1054 дүгээр захирамж | - Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн системийг ашиглах журмын хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br>- 2021 оны 10 дугаар сарын байдлаар хариутай 5, хариугүй 4 нийт 9 албан бичиг ирсэн. Албан бичгийн шийдвэрлэлт, хаалт тус бүр 100%. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 2.22<br>- 2021 оны 10 дугаар сарын байдлаар “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-аас ААНБ-уудад нийт 18 хариугүй бичиг явуулсан. Шийдвэрлэлт-100%<br>- 10 дугаар сард ээлжийн амралт авсан 1 албан хаагчийн мэдээллийг ERP системд оруулж амралтыг бүртгэлжүүлсэн. | 100% |
| 8. | ЗГ-ын 2009 оны 143, 2013 оны 411 дүгээр тогтоол | - 2021 оны 10 дугаар сарын байдлаар байгууллагын цахим хуудсанд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 3, цар тахалтай холбоотой 22, цаг үеийн шинж чанартай 36 мэдээллийг байршуулсан.<br>- Гал түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2021 оны 09 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн зохион байгуулагдаж байгаа "Алдвал галдана" сарын аяны контент, шторк, постерыг албан хаагчдадаа таниулан, байгууллагын цахим хуудас болон ажилчдын нийгмийн сүлжээгээр | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | дамжуулан олон нийтэд хүргэн ажилласан тухай тайланг 10 дугаар сарын 15-ны өдрийн 153 дугаартай албан бичгээр нийслэлийн Байгаль орчны газарт хүргүүлсэн.<br>- Монгол Улсын төрөөс соёлын талаар баримтлах бодлого, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.6.3, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 1.2, Багануур дүүргийн Засаг даргын 2021 оны А/161 дүгээр захирамжийн 4 дэх заалтуудын дагуу батлагдсан "Хотын соёл" аяныг зохион байгуулах удирдамжийн хүрээнд тусгай төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг хангaн ажиллаж байгаа тайланг сар бүрийн 20-нд дүүргийн Нийгмийн хөгжлийн хэлтэст, 25-нд НЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн Соён гэгээрүүлэх тасагт тайлагнан ажиллаж байна. | |
| 9. | Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль | - www.shilendans.mn сайтанд байгууллагын санхүүгийн мэдээллийг агуулга стандартын дагуу байршуулж байна.<br>- Байгууллагын 2021 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлан гаргаж 10 дугаар сарын 05-ны өдөр www.shilendans.mn сайтаас илгээсэн.<br>- Байгууллагын батлагдсан төсвийн дагуу сар, улирлын хуваарийг гаргаж зориулалтын дагуу зохистой зарцуулж байна. Сар бүрийн мэдээ, НД тайлан, татварын улирлын тайлан, санхүүгийн тайланг хугацаанд нь гаргаж байна.<br>- Дотоод аудит, хяналт шалгалтын удирдамжийн дагуу шаардлагатай баримт бичгийг файлаар бэлтгэн 10 дугаар сарын 27-ны өдөр нийслэлийн Дотоод аудитын газрын Ахлах дотоод аудиторын ERP болон цахим хаягт хүргүүлсэн. | 100% |
| 10. | Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 8.1.1 | - Ажилтнуудыг ажлын байранд нэвтрэхээс өмнө түрээслүүлэгч компанийн ажилтан биеийн халууныг хэмжиж, гарыг халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.<br>- Ажлын байранд хүний гар хүрэх газрыг 2 цаг тутамд ариутгаж, өдөр бүр агааржуулалтыг хийн, 7 хоногт нэг удаа их цэвэрлэгээг зохион байгуулан ажиллаж байна.<br>- Иргэдийн зорчих хөдөлгөөний мэдээллийг бүртгэх QR кодыг иргэдийн орох хэсэгт ил харагдахаар байршуулан хэрэгжилтэнд шууд хяналт тавьж байна.<br>- Бүх албан хаагчид коронавирусын эсрэг дархлаажуулалтын бүрэн тунд хамрагдсан.<br>- 2021 оны 05 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн байгууллагад коронавирусын халдвар бүртгэгдсэн эсэх судалгааг загвар хүснэгтийн дагуу гаргаж, 7 хоног бүрийн 1,3,5 дахь өдрүүдэд мэдээг шинэчлэн НЗДТГ-ын Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтний ERP чатад хүргүүлэн ажиллаж байна.<br>- Нийслэлийн Онцгой комиссын 2021.10.15-ны өдрийн 668 дугаартай албан бичгээр өгсөн чиглэлийн дагуу Дельта хувилбарын тархалт нэмэгдэж байгаатай холбогдуулан 10 дугаар сарын 18-ны өдрийн даргын зөвлөлийн хурлаар түрээслүүлэгч байгууллагад коронавирусын халдвар ихсэж, ажилтнууд халдвар авах эрсдэл өндөр гэж үзэн 0-12 насны хүүхэдтэй, гэрээсээ ажиллах хүсэлтэй албан хаагчдыг цахимаар ажиллуулахаар шийдвэрлэсэн. | 100% |

| | | |
|---|---|---|
| | **НЭМЭЛТ АЖИЛ** | |
| 11. | НУАШХ-аас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг НЗДТГ-ын О.Мандах мэргэжилтэн рүү хугацаанд нь хүргүүлэн ажиллаж байна. | 100% |
| 12. | Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны тайланг сар бүрийн 2, 4 дэх долоо хоногийн Пүрэв гарагт НЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст тайлагнаж байна. | 100% |
| 13. | Нийслэлийн 2022 оны төсвийн төсөлд тусгах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналыг хавсралт маягтын дагуу боловсруулан Багануур Үйлдвэрлэл, Технологийн Парк ОНӨТҮГ-ын 2021 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 141 дугаартай албан бичгээр НЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст, nzdtghbth2020@gmail.com цахим хаягаар тус тус хүргүүлсэн. | 100% |
| 14. | УИХ-ын Үйлдвэржилтийн байнгын хорооноос байгуулсан Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулах ажлын хэсэгт БҮТП ОНӨТҮГ-ын дарга оролцож 10 дугаар сарын 12, 21, 27-ны өдрүүдэд хуулийн төслийн хэлэлцүүлэгт орж ажилласан. Цаашид үргэлжлүүлэн 11 сард хуулийн төслийг УИХ-д өргөн барихаар тус ажлын хэсэг ажиллаж байна. | 100% |
| 15. | Барилгын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.5 дахь заалтын дагуу барилга байгууламжийн чанар байдлын судалгааг хавсралт маягтын дагуу боловсруулан 10 дугаар сарын 18-ны 154 дугаартай албан бичгээр нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газарт хүргүүлсэн. | 100% |
| 16. | ЗГ-ын 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 314 дүгээр тогтоолыг албан хаагчдад танилцуулж байгууллагын салбарт хэрэгжүүлж байгаа баримт бичгүүдийн жагсаалтыг гаргасан. | 100% |

ХЯНАСАН:
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК
ОНӨТҮГ-ЫН ДАРГА Ч. ЭЛБЭГСАЙХАН

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН:
ЗАХИРГААНЫ АЛБАНЫ
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Э.ЭНХЗАЯА